

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

**Байршил:** Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

**Эхлэх хугацаа:** 22/01/2021 **Дуусах хугацаа:** 22/02/2021

**Ажил эхлэх хугацаа:** 03/2021 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

## АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

### *Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:*

- Монгол Улсын хууль, үндсэн заавар, журмын дагуу архивын баримт бичгийг их сургуулийн алба, факультетууд /оюутны ажлыг оролцуулан/-аас хүлээн авах ажлыг зохион байгуулж, архивлах;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаатай холбоотой дотоод дүрэм журмыг шинэчлэх, боловсруулах ажилд оролцох;
- Байгууллагын баримт бичгийн ашиглалтыг хариуцан, цахим хэлбэрт шилжүүлэх;
- Ирсэн, явсан албан бичгийн хөтлөлтийг хийж, бүртгэлжүүлэн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэх;
- Албан бичиг төлөвлөх, боловсруулах.

### *Тавигдах шаардлага:*

- Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй эсвэл мэргэжлийн үнэмлэхтэй байх;
- Мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн байх;
- Англи хэлний А2 болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй бол давуу тал болно.

### *Бүрдүүлэх материал:*

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар - CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

### *Холбоо барих:*

Та бүх баримт бичгээ англи эсвэл монгол хэл дээр бэлтгэн ирүүлэх ба хэрвээ бичиг баримтын тань эх хувь англиас бусад хэл дээр бол англи хэл рүү хөрвүүлсэн байх ёстойг анхаарна уу. Тус ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж байгаа бол бичиг баримтаа зарласан хугацаанд багтаан [recruitment@gmit.edu.mn](mailto:recruitment@gmit.edu.mn) хаягаар цахим хэлбэрээр (1 PDF файл болгон эмхэтгэж) бидэнд ирүүлнэ үү.

**Цахим хуудас:** [www.gmit.edu.mn](http://www.gmit.edu.mn)

Бидэнтэй +976 7023-2090 тоот утсаар болон цахим хаягаар холбогдох боломжтой.

**Жич:** Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.